

ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯН-ОВОО СУМАНД МАА-Н ХӨГЖЛИЙН ШИНЭ ЗАГВАР НЭВТРҮҮЛЖ БАЙНА

Өдрийн сонины 2019 оны 02 сарын 25-ны дугаарт гарсан нийтлэл

Малыг тоог бус чанарыг эрхэмлэн эдийн засгийн эргэлтэд оруулах, түүхий эд бэлтгэлийн ченжийн тогтолцоог халж, нэг сум-нэг хоршоо зарчмаар боловсруулах үйлдвэрт гэрээгээр нийлүүлэх, эрүүл мэнд, чанарын стандартын шаардлагад нийцүүлэн өндөр үнэтэй зах зээлд хүрэх, экспортыг эрс нэмэгдүүлэх, МАА-н асуудлаа сумд дээш харалгүй шийдэх санхүүгийн найдвартай эх үүсвэртэй болох тулгамдсан асуудлуудыг цогцоор нь шийдэх загварыг төр-хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан оролцогч бүр хожих урамшууллаар дамжуулан нэвтрүүлж байна.

Баян-Овоо сум 1990 онд 56.2 мянга буюу 152 мянган хонин толгой малтай, 1 хонин толгойд 1.5 га бэлчээр ногдож, бэлчээрийн даац хангалттай, ган, зудын үед ашиглах нөөцтэй, малын ашиг шим одоогийнхоос өндөр байв. 2017 онд малын тоо 179.9 мянга буюу 352.5 мянган хонин толгойд хүрч, 1 хонин толгойд ногдох бэлчээр 0.6 га болтлоо буурч бэлчээрийн хүрэлцээ 2.3 дахин багасжээ. Бэлчээрийн даац хэтэрснээс мал хэвийнхээс 47 хувь дутуу идээшилж давжааран, ашиг шим нь багасахын зэрэгцээ өвчин, ган зудад эмзэгшин, зах зээлийн үнэлгээ нь буурч байна. Ган, зуднаар орох нөөц бэлчээргүй болж, эрсдэлд өртөмхий болсноос 2009-2010 оны зудаар малынхаа 20 шахам хувийг алдаж байв. Малаа зах зээлд ганц нэгээр сугачаа борлуулдгаас малын чанарт тавигдаж буй шаардлагыг хангаж, үнэ хүргэж чадахгүй байна. Малаа хотноосоо борлуулж байгаа нөхцөлд түүхий эдийн чанарыг хянаж, баталгаажуулах ямар ч боломжгүй, мал-эмнэлэг-ариун цэвэр, гарал үүслийн гэрчилгээ хоосон цаас гэдгийг хүн бүр мэддэг болжээ. Банкны зээлийн өндөр хүү төлж, орлого нь буурах явдал түгээмэл байна.

Малын тооны хойноос хөөцөлдсөн явцгүй сэтгэлгээг өөрчилж, бэлчээрт ээлтэй аргаар малчдын орлогыг нэмэгдүүлж амьжиргааг нь тогтвортой болгох цогц загвар болох “Ногоон бэлчээр” төслийг ХАС банк, Мерси Кор олон улсын байгууллагатай хамтран Бодлого судлалын төв Хэнтий аймгийн Баян-Овоо суманд 2018 оны 12-р сараас хэрэгжүүлж байна. Сумын 347 малчин өрх нэг бүрээр орж, төслийн ач холбогдол, ашиг хүртэх арга замыг сурталчилж, хэрэгжүүлэх нарийвчилсан хөтөлбөрийг сумын ИТХ-аар батлуулсан байна. Төслөөр 2019 онд сумын малчин өрхийн 20% буюу 84 өрхийг хамруулах юм.

Зээлийн хүүгийн дарамт. Ихэнх малчид хэрэглээний зээл авч, жилийн 24-30% хүү төлж байгаа нь тэдэнд санхүүгийн ихээхэн дарамт болж байв. Төсөл эхэлснээс хойш сар гаруйн хугацаанд жилийн 12% хүүтэй 500 сая төгрөгийн эко зээлийг 45 өрхөд олгосноор /1 өрх 11.1 сая төгрөг/ бусад банкнаас авсан өндөр хүүтэй зээлээ төлж, хүүгийн дарамтаас чөлөөлөгдсөн байна. 2018 оны байдлаар улсын хэмжээнд малчдын авсан зээл 300 гаруй тэрбум төгрөг байгаа бөгөөд энэ загвар нэвтэрвэл малчид 30 гаруй тэрбум төгрөгийн хүүгийн дарамтаас чөлөөлөгдөх юм.

Малын эдийн засгийн эргэлт. Мал өсгөх нь сайнтай ч, муутай ч, муу нь давамгайлах цаг нэгэнт иржээ гэдгийг нийтээрээ ойлгож, үүнд тохирсон бодлогоо хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Энэ нь малаа эдийн засгийн эргэлтэд оруулж, амиа аргацаасан бус таваарлаг аж ахуй болгох бодлого юм. Олох орлоготой нь холбож, ойлгомжтой тайлбарлавал малчид ийм бодлогыг хүлээж авдгийг төслийн сургалтад ашигласан загвар харуулж байна. Урьдынх шиг малаа жилд 6-10% өсгөөд явбал дундаж малчин өрхийн жилийн мөнгөн орлого одоо байгаа 11.3 саяас 5 жилийн дараа 12.8 сая болж өсөх бол малаа

бэлчээрийн даацад нийцүүлэн жилд 6% бууруулах үеийн мөнгөн орлого 5 жилийн дараа 18.1 сая болж, 41% илүү өсөж байна. Өөрөөр хэлбэл малчдын орлогыг бууруулах биш өсгөх замаар малын тоог цөөлөн бэлчээрийн даацад нийцүүлэх боломжтой. Малаа өсгөж байгаа үед тухайн жилийн төлийг оруулалгүйгээр малынхаа 15% орчмыг борлуулдаг бол мал цөөлөх үед 40% орчмыг борлуулж, зах зээлд нийлүүлэх мах 2.7 дахин өсөх юм. Ийм загвараар явбал Монгол улс жилдээ 650 мянган тонн мах үйлдвэрлэх нөөцтэй бөгөөд дотоод хэрэглээний 250 мянган тонныг хасвал 400 мянган тонныг экспортлох боломжтой юм.

Орон нутгийн санхүүжилт. МАА-н хөгжлийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэхэд тулгардаг үндсэн бэрхшээл нь санхүүжилтийн дутагдал юм. Хэдийгээр Төсвийн хуулийн 58.4-д МАА-н эрсдэл, бэлчээрийн менежмент, малын чанар, эрүүл мэндийн асуудлыг сумын төсөв, орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхээр заасан боловч тогтвортой эх үүсвэр байхгүйгээс хэрэгжихгүй байна. Төслийн хүрээнд уул уурхайгаас үл хамаарах сумын бие даасан МАА-н эрсдэлийн сан /МААЭС/-г төр-хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар бий болгож байна. Санд төсөлд хамрагдсан малчид малынхаа хонин толгой дутам 500 төгрөгийг сайн дураар, төслийн зүгээс 300 төгрөгийг оруулж байгаа юм. 2019 онд энэ санд 84 өрхийн 70.4 мянган хонин толгойгоос 35.2 сая, төслөөс 21.2 сая нийт 56.4 сая төгрөг төвлөрнө. Зарцуулалтын хувьд бэлчээр, тэжээл, ус, малын чанар, эрүүл мэнд, түүхий эд боловсруулах, борлуулах гээд нэр бүхий 21 арга хэмжээнд зориулж малчдаас гарах саналыг санхүүжүүлэхэд 25.7 сая, сумын төвд байгуулах малын чанарыг хянаж, баталгаажуулах цэгээр малаа борлуулсны төлөө 21.1 сая, нийт 46.9 сая төгрөгийг малчдад эргүүлээд олгох бөгөөд үлдэх 9.5 сая төгрөгийг сумын МАА-н нийтлэг арга хэмжээнд зарцуулна. Төслөөс гарах хөрөнгийг цаашид Төсвийн хуулийн дагуу орон нутгийн төсвөөс гаргана. Сумын нийт малчид хамрагдсан нөхөлд санд малчдаас 150, төсвөөс 90, нийт 240 сая төгрөг төвлөрнө. Төсвөөс гарах 37.5%-н эх үүсвэр нь дийлэнхийг малчид гаргах хөшүүрэг болж буй хэрэг бөгөөд суманд 200 гаруй сая төгрөгийн эх үүсвэр бүрдэж, дээш харалгүй тулгамдсан асуудлаа шийдэх санхүүжилттэй болж байна. Улсын хэмжээнд бол 20 гаруй тэрбум төгрөг төсвөөс гаргаад 60 гаруй тэрбум төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэх тул боломжтой шийдэл юм. Дундаж малчин өрх 420 мянган төгрөг оруулаад 560 мянган төгрөг болгон авч ашиг хүртэж байна. Энэ загвар нь одоогийн эрх зүйн орчинд нийцүүлэн хөрөнгө босгож буйгаараа татвар, бэлчээрийн төлбөр мэтийн хугацаа шаардсан эмзэг асуудлыг шийдэгдтэл хүлээж суухгүй байх практик гарц юм.

Бэлчээрийн менежмент. Бэлчээрийн менежментийг сайжруулах талаар олон тооны төсөл, хөтөлбөр хэрэгжсэн боловч бэлчээрийн доройтлын суурь шалтгаан болсон малын тооны хэт өсөлтийг зогсоож чадаагүй юм. Даац хэтэрч, булан тохой бүр эзлэгдсэнээс бэлчээрийн сэлгээ, өнжөөх, оторлох зэрэг бусад арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй болж, тэдгээрийн үр өгөөж эрс багассан байна. Иймд дэс дарааллын хувьд эхлээд даацад тохирох малтай болж байж бусад арга хэмжээний үр өгөөж дээшилнэ гэсэн үг. Төслөөр энэхүү гол гогцоо асуудалд анхаарлаа хандуулж малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэн бууруулах зорилтыг сонирхлын хөшүүргүүдээр хэрэгжүүлж байна. Төсөлд хамрагдсан малчин өрх болон малчдын бүлэг бүр сумын Засаг даргатай гэрээ байгуулж, малын тоог бууруулах, малаа нэг цэгээр дамжуулан борлуулах, МААЭС-д хандиваа төлөх, эдгээр арга хэмжээнээс эргүүлээд ашиг хүртэх, үүргээ биелүүлээгүй бол хүлээх хариуцлага зэрэг нөхцөлөө тодорхой тусгасан юм. Тухайлбал малын тоог цөөлөх үүргээ биелүүлээгүй бол зээлийн хүүгийн хөнгөлөлттэй нөхцөлийг цуцлах, МААЭС-д хандиваа төлөөгүй бол бэлчээрийн менежментийн саналаа хэрэгжүүлэх санхүүжилт авахгүй юм. Малын тоо

бэлчээрийн даацад тохирсноор малчдын хөдөлмөрийн ачаалал багасаж, амьдралын чанар дээшлэн малчдын залуу халааг татах нэг нөхцөл бүрдэнэ.

Түүхий эд бэлтгэл, хоршоо. МАА-н үйлдвэрлэлийг малчид өрх, фермерээрээ тус тусдаа эрхэлж, харин өртгийн сүлжээ буюу малчны хотноос эцсийн хэрэглэгч хүртэл бүх шат дамжлага дээр хоршоо хэлбэрээр хамтран ажиллаж, зардлаа хэмнэж, ашгаа нэмэгдүүлдэг олон улсын нийтлэг жишиг байна. Манайд малчдын хоршоо хөгжихгүй байгаагийн үндсэн шалтгаан нь тэднийг оролцуулж, ашиг хүртээх эдийн засгийн хөшүүрэг байхгүйд байна. Төслөөр түүхий эдээ хувь хувиараа ченжид борлуулдаг тогтолцоог халж, нэг цэгт төвлөрүүлэн чанар, эрүүл мэнд, гарал үүслийг нүдээр үзэж баталгаажуулсан /зөвхөн энэ үндсэн дээр гэрчилгээ олгоно/ малыг стандартын шаардлага хангасан боловсруулах үйлдвэрт гэрээний үндсэн дээр нийлүүлнэ. Малчид малаа нэг цэгээр оруулсны төлөө МААЭС-аас мөнгөн урамшил авахаас гадна баталгаажуулсан малаа зах зээлийн үнээс 10% орчим өсгөсөн чанарын урамшуулалт үнээр борлуулах юм. Үүнд оролцогч мах боловсруулах үйлдвэрт эргэлтийн хөрөнгийн хөнгөлөлттэй зээл олгоно. Ийнхүү оролцогч бүр хожих эдийн засгийн урамшууллаар дамжуулан МАА-н түүхий эдийг бөөгнүүлэн нэг сум-нэг хоршоо зарчмаар чанарын цогц хяналт тавьж, малчдад ашиг хүртээдэг, дотоод, гадаадын зах зээлийн шаардлагыг ханган өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх юм. Ингэснээр ноос, ноолуур, арьс шир, сүү гээд бүх түүхий эдийн бэлтгэлийг зохион байгуулах загварыг бий болгож байна.

Малын эрүүл мэнд, чанар. Малын эрүүл мэнд, чанар муудсаар байгаагийн суурь шалтгаан нь эдийн засгийн хөшүүрэг, сонирхлын механизмдаа байна. Малын эрүүл мэнд, чанарт хөрөнгө оруулж, илүү зардал гаргасан малчны бүтээгдэхүүн нь нэг ч төгрөг зараагүй малчны бүтээгдэхүүнтэй ижил үнэлэгддэгээс хичээл зүтгэл гаргасан нь алдагдалд орж, зүгээр суусан нь хождог учир малчид сонирхолгүй болж, тоогоо өсгөөд суух нь амар болоод байгаа юм. Ийнхүү сонирхлын хөшүүрэг нь буруу байгаагаас гаргасан хууль, хөтөлбөр нь хэрэгждэггүй, төсвөөс тэрбумаар нь хөрөнгө зараад ч үр дүнгүй болж байна. 2010 оны “Монгол мал” хөтөлбөрөөр сум бүрд Мал эмнэлэг, үржлийн тасгийг 3 хүний орон тоотойгоор байгуулсан боловч эрэлтгүй зүйлд оруулсан хөрөнгө дампуурдаг жамаар эдгээр хүмүүс хийх мэргэжлийн ажил багаас тамгын газрын нөхөөс болж хувирсан, нөгөө талдаа малын чанар, эрүүл мэнд муудсан юм. УИХ-аар баталсан Малын эрүүл мэнд, генетик нөөцийн тухай хуулиудаар эдгээр орон тоог дахин нэмэхээр болсон ч эрэлтээ бодохгүй бол өнгөрсөн гашуун үнэн давтагдахаар байна. Мал эрүүл, ашиг шимтэй байхын үндэс нь бүрэн хооллолт, харин бэлчээрийн даац хэтэрснээс мал хэрхэн дутуу хооллож, давжаарч буйг дээр дурдсан билээ. Төслөөр энэ байдлыг өөрчилж малын эрүүл мэнд, чанарыг сайжруулахыг малчдын өөрсдийнх нь бодит эрэлт болгох сонирхлын хөшүүргийг нэвтрүүлж байна. Юуны өмнө малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэх эдийн засгийн хөшүүрэг болгон хөнгөлөлттэй эко зээл олгож байгааг дээр дурдсан. Бэлчээр хангалттай болсноор мал эрүүлжиж, чанаржих суурь нөхцөл бүрдэнэ. Нэг цэгээр орж баталгаажсан малд олгох чанарын урамшуулал нь эдийн засгийн гол хөшүүрэг юм. Гарсан зардлаа үнийн урамшууллаас нөхөж, ашиг олох тул малчид малаа эрүүлжүүлж, чанарыг сайжруулахын төлөө зүтгэж, хөрөнгө зардаг болно, малын эмч, зоотехникч нар зах зээлийн жамаар бодит ажилтай болж, төсвийн гар харж суудаг, хуурамч гэрчилгээ, падаан бичиж, амиа аргацаадгаа болих юм. Монгол улсын түүхий эдийн чанар, гарал үүслийн гэрчилгээ бодит үнэ цэнтэй болж, зах зээлд Монгол чанарын баталгаа болж сая чадах юм.

Уламжлалт МАА-н өрсөлдөх чадвар, гадаад зах зээл. Өнөө үед эрчимжсэн аргаар үйлдвэрлэсэн хүнс, түүхий эдийн амт чанар, эрүүл мэндийн баталгаа эргэлзээтэй болж,

байгалийн цэвэр бүтээгдэхүүнийг эрэлхийлэх хандлага дэлхийн зах зээлийг тодорхойлж байна. АНУ-д эрчимжсэн фермийн хүчит тэжээлээр бордсон үхрийн мах шүүс багатай байдгаас гадна зүрх судасны өвчнөөс сэргийлдэг Омега-3 тосны хүчлийн агууламж бэлчээрийн махнаас 2 дахин бага байдаг тул үнэ нь 11 доллар байхад бэлчээрийн органик мах 17.4 доллар буюу 58%, 16000 төгрөгөөр илүү байна. БНХАУ-д байгаль орчны бохирдол хурцдаж, хүн амын орлого нэмэгдэж байгааг дагаад органик бүтээгдэхүүний зах зээл сүүлийн 10 жилд 30 дахин өссөн байна. Үүнээс улбаалан өвөр Монголын байгалийн бэлчээрт идээшилсэн органик малын мах үнэд орж байна. Бээжинд үхрийн мах кг нь 76 юань буюу 10.7 доллар байгаа бол өвөр Монголын органик хонины мах кг нь 104 юань буюу 15 доллар байна. ОХУ-ын төвийн хотуудад органик үхрийн мах ангиллаасаа хамаараад кг нь 650-2300 рубль байна. Ийнхүү өндөр хөгжилтэй бүс нутаг төдийгүй манай хөрш орнуудад органик хүнсний үнэ массын хэрэглээний хүнснээс өндөр үнэтэй, хүн амын орлогын өсөлтийг дагаад цаашид ч эрчимтэй өсөх хандлагатай байна. Монголын уламжлалт 5 хошуу мал бол нэгжийн ашиг шимээр доогуур ч бэлчээрийн органик бүтээгдэхүүн гэдгээрээ өндөр үнэ хүрнэ. Гаднын массын хямд зах зээлийг биш харин өндөр үнэтэй зорилтот зах зээлд хүрэх нь бидний зорилго юм. Гагцхүү энэхүү зорилгод хүрэх бодлогоо цаг алдалгүй хэрэгжүүлмээр байна. Олон улсын зах зээлд органик хүнсэнд тавигддаг гол шаардлага болох эрүүлийг баталгаажуулсан байх, байгальд ээлтэй буюу бэлчээрийн даац хэтрээгүй байх 2 гол үзүүлэлт нь манайд биелээгүй байгаа юм. Үүнийг хэрэгжүүлэх загварыг батлан харуулж байгаад төслийн ач холбогдол оршино.

Загварыг дэлгэрүүлэх нь. Загвараар хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь үр дүнгээ өгч байна. Иймд энэхүү загварыг бусад аймаг, сумдад дэлгэрүүлэхийг холбогдох яамд, аймаг, сумд, банк, санхүүгийн байгууллага, боловсруулах үйлдвэрүүдэд уриалж байна. Үүнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам /ХХААХҮЯ/-ны манлайлал чухал.

Энэхүү загварыг 10 жилийн хугацаанд нийт сумдад нэвтрүүлэх боломжтой. Сумдын 20%-г эхний жил, 2 дахь жилээс 40% гэх мэтээр 5 жилд бүх сумд хамрагдана. Тухайн сумын хувьд эхний жилд нийт малчин өрхийн 20% дараагийн жил 40%, 5 дахь жилдээ 80-100% хамрагдах боломжтой. Ийм замаар 5 дахь жилд хамрагдсан сумдын өрхүүд бүрэн хамрагдталаа дахин 5 жил шаардах юм. Санхүүжилтийн хувьд юуны өмнө олон улсын байгууллагын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл зохистой. Тухайлбал, Дэлхийн банкны зүгээс ХХААХҮЯ-д санал болгож буй “МАН-н салбарын эдийн засгийн эргэлтийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх” хөтөлбөрийн 50 сая ам долларыг энэ зориулалтаар ашиглавал нэн үр дүнтэй болно. Үүнд 20 орчим сая ам долларыг малын чанар, эрүүл мэндийг сайжруулах чиглэлийн төвлөрсөн хөрөнгө оруулалт, үндэсний байгууллагууд, мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлэх болон хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг санхүүжүүлж, үлдэх 30 сая ам долларыг Монгол улсын нийт 330 сумдад хуваавал 1 суманд 90 орчим мянган доллар буюу 240 сая төгрөг болох юм. Үүнийг дээрх загварыг нэвтрүүлэх, МАН-н эхний санхүүжилтийг гаргаж, цаашид төвөөс гаргах сэтгэлгээ, арга замыг төлөвшүүлэх, түүхий эдийн чанарыг хянаж, баталгаажуулах цэгийг ажиллуулах, нэг сум-нэг хоршоо тогтолцоог хөгжүүлэх, ХААН-н биржтэй холбох, экспортыг дэмжихэд зарцуулж болно. Хөнгөлөлттэй эко зээлийн хувьд Монгол улсын Хөгжлийн банк болон олон улсын санхүүгийн байгууллага /IFC, ADB, EBRD г.м./-д саналаа тавьж шийдвэрлүүлж болно. Мөн хүлэмжийн хийг бууруулах төсөл, хөтөлбөрийг дэмжиж жилдээ хэдэн тэрбум долларын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл олгодог Ногоон уур амьсгалын сан /Green Climate Fund/-д хандаж болно. Малыг тоо өссөнөөр гарах хүлэмжийн хий нь манай орны

нийт хийн 30 шахам хувийг бүрдүүлэх болсон тул тоог цөөлж, хүлэмжийн хийг бууруулах санал дэмжигдэх нь дамжиггүй. Хүлэмжийн хийгээ 2030 оноос өмнө 30% бууруулна гэж манай улсын хүлээсэн үүрэг ч бий. Малын түүхий эдийг худалдан авахад нь зориулж эргэлтийн хөрөнгийн зээл, хүүгийн хөнгөлөлт олгодог практик одоо ч байгаа. Гагцхүү үүнийг олгохдоо чанарын шаардлага хангасан түүхий эдийг урамшуулалт үнээр авах нөхцөлийг нэмэхэд л болох юм. Чанартай түүхий эд авснаараа зардлаа хэмнэж, бүтээгдэхүүний чанар дээшлэх тул ийм зээл олгох нь боловсруулах үйлдвэрийн эрх ашигт нийцнэ. Хөгжлийн болон арилжааны банкнудаас олгож буй хэдэн зуун тэрбумын ноолуурын зээл /микрон, уртаар ялгавартай үнэтэй байх/, нөөцийн мах бэлтгэхэд олгож байгаа зээл, ЖДҮ-г дэмжих сан, ноосны урамшуулал зэргийг дээрх загварын дагуу өөрчилж, түүхий эдийн чанарыг сайжруулах малчдын сонирхлыг урамшуулахад санаачилга л хэрэгтэй байна. Төвлөрсөн эх үүсвэрийг хүлээлгүй өөр өөрийн боломжийг хайвал манай банк, төсөл, хөтөлбөр, боловсруулах үйлдвэр, аймаг, сумдад ч нөөц бий. Үүний нэг тод жишээ нь малчдын эко зээлийг санаачлан хэрэгжүүлж буй ХАС банк, зөвлөх үйлчилгээг санхүүжүүлж байгаа Мерси Кор байгууллага, загварыг амжилттай нэвтрүүлж буй Баян-Овоо сумын манлайлал юм.

БОДЛОГО СУДЛАЛЫН ТӨВ www.cpr.mn